

**ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН  
2022 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ  
/2022 оны гуравдугаар улирлын байдлаар/**

2022 оны 10 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Биелэлт
<b>Зорилго 1: Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх</b>			
1	1.1.АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх;	Жилдээ	Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн тв шторк, гарын авлага зэргийг байгууллагын албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (Фэйсбүүк, youtube суваг)-аар дамжуулан иргэд олон нийтэд ил тод мэдээлэн ажиллав.
2	1.2.Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах;	Жилдээ	2022.04.04-ний өдөр НЗДТГ болон АТГ-ын хамтран зохион байгуулсан “Шударга ёсыг эрхэмлэе” нийслэлийн зөвлөгөөнд газрын удирдлага болон хэлтсийн дарга нар оролцсон.
3	1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах;	Жилдээ	Авлигын эсрэг үйл ажиллагааг байгууллагын цахим хуудас болон фэйсбүүк хуудсаар дамжуулан тогтмол мэдээлэн сурталчлан ажиллаж байна. Мөн “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар байршуулан нийт албан хаагчдад авлигатай тэмцэхтэй холбоотой тараах материал хүргүүлэн мэдээ мэдээллээр тогтмол ханган ажиллав.
<b>Зорилго 2: Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг нараа АТГ- аас зохион байгуулах сургалтад хамруулах</b>			
4	2.1.Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар 01 дүгээр сарын 25-ны дотор АТГ-ын УССГХ- т хүргүүлсэн байх;	1 дүгээр улиралд	Авлигын эсрэг сургалтад шинээр томилогдсон албан хаагчдыг хамруулахаар албан хаагчдын судалгааг цахимаар хүргүүлсэн.
5	2.2.АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан шатны сургалтад албан хаагчдаа хамруулсан байх;	Жилдээ	Авлигын эсрэг анхан шатны сургалтад шинээр томилогдсон албан хаагчдыг хамруулахаар албан хаагчдын судалгааг

			НЗДТГ-т хүргүүлсэн. 2022 оны гуравдугаар улирлын байдлаар авлигын эсрэг анхан шатны сургалтад хамрагдсан албан хаагч байхгүй байна.
6	2.3.АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг давтан сургалтад албан хаагчдаа хамруулсан байх;	Жилдээ	Авлигатай тэмцэх газраас цахимаар болон танхимаар зохион байгуулсан авлигын эсрэг сургалт, эрх бүхий албан хаагчдад зориулсан сургалтад байгууллагын эрх бүхий албан тушаалтныг тогтмол хамруулан ажиллав.
7	2.4.Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан иргэд, хүүхэд залуус хүргэх шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүн тооцож, тайлагнасан байх;	Жилдээ	Авлигатай тэмцэх газраас цахимаар зохион байгуулах сургалт болон соён гэгээрүүлэх үйл ажиллагааны мэдээллийг тогтмол албан хаагчдад хүргэн ажиллаж байна. Мөн нийт албан хаагчдад хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бөглөх талаарх мэдээллийг тогтмол өгч арга зүйгээр ханган ажиллаж байна.
<b>Зорилго 3: Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх</b>			
8	3.1.Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх	Жилдээ	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу нийтийн албан шинээр томилогдож буй албан хаагчаас хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хүлээн авч холбогдох материалын хамт Авлигатай тэмцэх газрын Дүн шинжилгээ хяналт, шалгалтын хэлтэст тухай бүр хүргүүлэн ажиллав. 2022 оны гуравдугаар улирлын байдлаар 16 албан хаагчийн урьдчилсан мэдүүлгийг хянуулсан бөгөөд хуулийн хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авч баталгаажуулан ажиллав.
9	3.2.Мөрдөгчийн мэдэгдэлд тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх		2022 оны гуравдугаар улирлын байдлаар тус газарт мөрдөгчийн мэдэгдэл болон авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал ирээгүй болно.
10	3.3.Зөрчил арилгуулах албан бичигт тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх		2022 оны гуравдугаар улирлын байдлаар тус газарт зөрчил арилгуулах албан бичиг болог авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал ирээгүй болно.
<b>Зорилго 4: Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх</b>			
11	4.1.Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аянд нэгдсэн байдал;	Жилдээ	Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аянг тогтмол дэмжин ажиллаж байна.

12	4.2.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;		Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд хамтран ажиллах гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх зүйл заалтыг тусгасан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.
Зорилго 5: Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах			
13	5.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх/ Үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/	Жилдээ	Тус газар нь чиг үүргийн хүрээнд барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. <a href="http://www.e-mongolia.mn">www.e-mongolia.mn</a> цахим системээр “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлт”-ийг хүлээн авч үйлчилгээг цахимжуулан иргэд аж ахуйн нэгж байгууллагуудад төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэн ажиллаж байна.
Зорилго 6: Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах			
14	6.1 - Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4; - Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 - Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээрээ байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах;	Жилдээ	Авлигын эсрэг хууль, Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиудын хэрэгжилтийг хангуулан, иргэд олон нийтэд байгууллагын цахим хуудсаар дамжуулан мэдээ мэдээллийг ил тод нээлттэй хүргэн ажиллав. Мөн байгууллагын шилэн дансны мэдээлэлд эрх бүхий албан хаагчдын хувийн ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл тайлбарыг тогтмол байршуулан ажиллаж байна.

ХЯНАСАН:  
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:  
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Э.ДАВААХАТАН



С.БОЛДОО